

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР”- ҮН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН

2022.12.09

Дархан

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулж буй “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР”-ын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалаар дамжуулан орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэн ажиллав.

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газраас орон нутгийн соёл, урлагийн байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж дараах 4 чиглэлийн хүрээнд ажиллав. Үүнд:

- 1 дэх 7 хоног – Үндэсний нэгдмэл үнэт зүйл;
- 2 дах 7 хоног – Бүх нийтийн соёлын боловсрол;
- 3 дах 7 хоног – Соёлын үйлдвэрлэл;
- 4 дэх 7 хоног – Соёлын аялал жуулчлал;

“Соёлын бүтээлч сар”-ын үйл ажиллагаанд аймгийн соёл, урлагийн байгууллагууд, Залуучууд театр, аймгийн музей, Төв номын сан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын соёлын төв, гадна соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарын байгууллага, үйлдвэрлэл эрхлэгч аж, ахуйн нэгж байгууллага, иргэд, дугуйлан, холбоодыг өргөнөөр татан оролцуулсан болно.

Бүтээлч сарын туршид 134 ажлыг амжилттай хэрэгжүүлэн давхардсан тоогоор нийт 69050 хүнд соёл, урлагийн үйлчилгээг хүргэсэн байна. Энэ нь нийт хүн амын 64,5 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулсан ажлуудын талаарх мэдээллийг аймгийн ИТХ, ЗДТГ-ын газар, хэлтэс агентлагуудад албан ёсоор танилцуулахын зэрэгцээ орон нутгийн DBS, RGB телевиз, аймгийн Мэдээлэл технологийн алба, Монцамэ агентлаг, Цэц.мн, <http://da.mos.gov.mn> сайтуудаар иргэд, олон нийтэд мэдээлж ажилласан.

СОЁЛЫН ЯАМ ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР МУЗЕЙ ИТХ THE ОРХОН ХОНГОР ШАРЫН ГОЛ СОЁЛЫН ТӨВ DBS RGB телевиз аймгийн Мэдээлэл технологийн алба Монцамэ агентлаг Цэц.мн, <http://da.mos.gov.mn>

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР 2022.11.01-30

I долоо хоног
ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ
Үндэсний бахархал, эв нэгдэл

II долоо хоног
БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ
Бүх нийтийн соёлын боловсрол

III долоо хоног
СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ
Соёлын бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар

IV долоо хоног
СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
Орон нутгийн тогтвортой хөгжил.

Аймгийн Соёл, урлагийн газрын дарга 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Соёлын бүтээлч сарын эхний 7 хоногийн төлөвлөгөө, 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр бэлтгэл ажлын төлөвлөгөө, 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр нэгдсэн ажлын төлөвлөгөөг тус тус батлаж, соёлын байгууллагууддаа чиглэл хүргүүлэв.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл 1 дэх 7 хоногийн батлагдсан төлөвлөгөө, Соёлын бүтээлч сарын бэлтгэл ажлын төлөвлөгөө, Соёлын бүтээлч сарын нэгдсэн төлөвлөгөөг тайланд хавсаргаав. /

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САРЫН ХҮРЭЭНД ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ БУЮУ 1 ДЭХ 7 ХОНОГТ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар болон соёлын байгууллагуудын удирдлагууд 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хэвлэлийн бага хурал хийж Соёлын бүтээлч сарын хүрээнд хийхээр төлөвлөсөн ажлуудаа иргэд, олон нийтэд сурталчилснаар ажлаа эхлүүлсэн.



ЗАЛУУЧУУД ТЕАТР: Соёлын бүтээлч сарын эхний өдрүүдэд буюу 11 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд аймгийнхаа Орхон, Хонгор сумдад бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж нэгэн өдрийн туршид урлаг, соёлоор үйлчилсэн.


“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Дархан-2032” хөтөлбөрийн хүрээнд шинээр найруулан тавьсан “Шидэт модны үр” хүүхдийн жүжгийг тус сумдын нийт 550 хүүхдэд үзүүллээ. Тус жүжгээр дамжуулан хүүхэд багачуудын экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль дэлхийгээ хайрлах зөв сэтгэлийг төлөвшүүлэхийг зорьж байгаа аж. Хүүхдийн жүжигт мэргэжлийн уран бүтээлчдээс гадна драмын дугуйлангийн сурагчид зэрэг нийт 50 гаруй уран бүтээлч оролцсон.

Хүүхдийн жүжгээс гадна Хонгор, Орхон сумын 370 гаруй иргэдэд “Алтан намар” уран бүтээлийн тоглолтыг тоглож, үдэш нь нийтийн цэнгүүнийг зохион байгуулсан.



Мөн Залуучууд театраас 11 дүгээр сарын 05-ны өдөр Өсвөр насны хүүхдүүдэд зориулсан “**Open mic**”, 11 дүгээр сарын 06-ны өдөр хүүхэд багачуудад зориулсан “**Шидэт ертөнц**” тоглолтыг тус тус зохион байгуулав.

Бүтээлч ажлын хүрээнд тус театрын Маркетингийн албанд шинэ компьютер авч суурилуулан их заалны 24 лед гэрлийг шинэчилсэн.



Шинэ уран “Нэр зээлдэгч” жүжгийг тус сардаа багтаан тавихаар бэлтгэл, уншлага эхлүүлсэн. Жүжгийн тайзны эскиз зургийг гаргаж батлуулсан.

Мөн Залуучууд театрыг сурталчлах хүрээнд ОИЦ сургуулийн 9-12 ангийн 150 гаруй сурагчдад уран бүтээлийн 4 ангийн онцлогоо танилцуулж уран бүтээлээ өргөн барихаар бэлтгэл ханган ажилласан.

АЙМГИЙН МУЗЕЙ: "Соёлын бүтээлч сар"-ын 1 дэх долоо хоног буюу "Үндэсний нэгдмэл үнэт зүйл"-ийн хүрээнд хамт олноороо "Чингис хаан" музейг үзэж шинэ музейн үйл ажиллагаа, зохион байгуулалт, үзүүлэлэг дэглэлт зэрэг тэргүүн туршлагаас суралцлаа.

Мөн Монголын Уран зургийн галерейгаар зочилж, хосгүй үнэт бүтээлүүд болон "Оны шилдэг бүтээл-2022" үзэсгэлэнг үзэв.



Аймгийн музейд 2022 оны 11 дүгээр сарын 02-05-ны хугацаанд “Монгол наадгай – Бидний өв” боловсролын хөтөлбөрт Оюуны Ирээдүй цогцолбор сургуулийн 4 дүгээр ангийн 6 бүлгийн нийт 235 хүүхэд багачуудыг хамруулав. Мөн Ахмадын хөгжлийн төвийн ахмадуудыг тус хөтөлбөрт хамруулсан.

Мөн аймгийн Музейгээс сарын хугацаанд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг захирал Д.Жамбалдорж төв, орон нутгийн телевизэд ярилцлага өгч сурталчиллаа.



ТӨВ НОМЫН САН: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд буюу 4 долоо хоногийн хугацаанд төр, хувийн хэвшлийн 14 байгууллагатай хамтран 20 гаруй ажлыг хийхээр төвлөсөн.

Бүтээлч ажлын хүрээнд Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн лавлагаа, мэдээллийн цахим санд “**Найрамдлын Дархан**” сонины дутуу хавсралтыг аймгийн Төрийн архиваас нөхөн бүрдүүллээ. Ингэснээр 1983, 1984, 1985, 1986, 1988 оны 426 дугаар 1737 хуудас 6922 талыг цахим сүлжээнд оруулсан..

Аймгийн Цэргийн штабтай хамтран “**Бид эх орны ирээдүй**” эсээ бичлэгийн уралдааныг ЕБС-ийн ахлах ангийн сурагчид болон МСҮТ, Политехникийн коллежийн оюутнуудын дунд зарлаж дүгнэсэн. Тус уралдаанд аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, техник, мэргэжилийн коллеж зэрэг нийт 16 сургуулийн 212 сурагч, оюутнууд оролцсон бөгөөд эхний 10 байранд шалгарсан хүүхдүүдийн эсээ бичлэгээр хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уралдааны шилдэг оролцогчдын шагналыг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Д.Пүрэвсүрэн, Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд, арга зүйч С.Нэргүй нар гардуулан өгөв.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн:

- Эзэн Богд Чингис хаан сэдэвт үзэсгэлэнг 2 удаа 64 боть номоор үзэсгэлэн гаргаж, байгууллага дээр Чингис хааны иш хөргийг хүндэтгэн залах ёслол хийв.
- Шинээр ирсэн 47 боть номоор
- Монголын кино урлаг болон жүжгийн зохиолын номнуудаар сэдэвчилсэн
- Үндэсний өвийг уламжилъя сэдвийн дор Цам харайх ёсны тухай болон Монголын уламжлалт зан үйл сэдвээр 2 удаа 84 боть номоор нийт 5 удаа 195 боть номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж танхимаар танилцуулах болон цахимд байршуулан уншигч иргэдэд сурталчиллаа.



Угийн бичгийн сургалт: Монгол хүн бүрийн, тэр дундаа ураг удамдаа мэдэх зайлшгүй шаардлагатай зүйл бол Угийн бичиг юм. Төв номын сангийн зүгээс угийн бичгийн сургалтыг тогтмол зохион байгуулдаг ба энэ удаад Дархан сумын 15 дугаар багийн хэсгийн ахмадуудын төлөөлөлд Угийн бичиг хөтлөх тухай, угийн бичгийн ач холбогдол сэдвээр сургалт хийлээ.

"Соёлын бүтээлч сар"-ын эхний долоо хоногт "Гэр бүлийн үнэ цэнэ - ёс заншил" лекцийг төрийн байгууллагуудад зохион байгуулав. Тус лекцийг "Жаргалант Дархан" ТББ-ын Тэргүүн, Гэр бүл судлаач Б.Дэмбэрэлмаа уншиж хүргэсэн ба лекцийн үеэр Монгол уламжлалт арга ухаан, гэр бүлийн үнэ цэн, соёлын өвийн талаарх сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргав.

"Үндэсний өв соёл" үзэсгэлэнгээр үндэстэн ястнуудын эд, соёлын онцлог, соёлын биет бус өвийн талаарх судалгаа, зураг өгүүлэмжүүд, дуу хөгжмийн төрөл зэмсэгийн тухай, Монгол бэлгэдэл зүй, Монгол хувцасны түүх зэргийг агуулсан 30 гаруй ном багтлаа.



Тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах тухай мэдээллийг аймгийн Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд ШУТИС-ийн 1, 2 дугаар курсын оюутнууд болон лицей сургуулийн сурагчдад өгөв. Мэдээлэлд АНУ-д зочлох гэр бүлийн хөтөлбөр, ЮТА, Аризона, Флорида дахь 3 долоо хоногийн хөтөлбөр зэрэг хэд хэдэн чиглэлийн сургалтын хөтөлбөр багтаж байгаа бөгөөд оюутны, сурагчид ELTIS-ийн түвшин 215-аас дээш байх шаардлагатай юм байна.



ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОН: Тус ордноос “Соёлын бүтээлч сар”-ын нээлтийг аймгийн ЕБС-ийн 12 дугаар сургуулийн багш, ажилтнуудыг оролцуулсан “Өглөөний кофетой уншлага”-аар эхлүүллээ. Нийт 36 багш, ажилтнууд өглөө эрт /06:30-07:50/ хүрэлцэн ирж ордны үйл ажиллагаа, шинэ номтой танилцан “Хүүхдийг ном унших арга зүйд хөтлөх” нь сэдвээр сургалт мэдээлэл авч, 20 минутын уншлага хийсэн.



“Монголын нууц товчоо” сэдвээр зохион байгуулах “Алтан хонх”, жил бүр ЕБС-ийн сурагчдын дунд уламжлал болгон зохион байгуулдаг оны шилдэг шүлэг шалгаруулах “Найргийн даага” уралдааны удирдамж, болзлыг боловсруулж Хүүхдийн номын ордон, аймгийн СУГ, бусад мэдээллийн хуудсуудаар олон нийтэд түгээн сурталчиллаа.


“Од” цогцолбор сургуулийн 7-р ангиудын сурагчдын төлөөлөл 12 сурагчид “Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол” сэдвээр сургагч багш С.Оюунцэцэг сургалт зохион байгууллаа.



Бага насны хүүхдүүдийг ХНО-ны үйл ажиллагаатай танилцуулах, ном унших сэдлийг төрүүлэх, номд дуртай болгох, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэхэд хөтөч болох зорилгоор “Танилцах аялал” арга хэмжээг тогтмол зохион байгууллаа. Эхний 7 хоногт “Дархан Эмпати” сургуулийн Б.Болор багштай 16 анги, 10-р цэцэрлэгийн бэлтгэл “Б” бүлгийн бяцхан хүүхдүүд, нийт 46 ирээдүйн уншигч хүүхдүүд Хүүхдийн номын ордны үйл ажиллагаатай танилцаж, зурагт ном сонирхож, “Гоё үлгэр” номоос чанга уншлага хийлээ.



ШАРЫН ГОЛЫН СУМЫН СОЁЛЫН ТӨВ: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Шарын гол суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын албан хаагчдын дунд **"Номтой - оюунлаг төрийн албан хаагч"** [CHALLENGE] –ыг эхлүүлсэн. Эхний 7 хоногт сумын ЗДТГ-ын 16, Шарын гол сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн 7 албан хаагч нэгдсэн.



“Үндэсний нэгдмэл байдал” агуулгын хүрээнд зохиолч яруу найрагчдын уулзалт, өдөрлөгийг төлөвлөж зурагт постер, урилга, уулзалтын байр, өдөрлөгийн хөтөлбөр, Яруу найрагчдын танилцуулга зэргийг бэлтгэсэн.

Төрийн байгууллагууд хувь хүний хөгжлийг дэмжин, байгууллагынхаа соёлыг тодорхойллоо.

Шарын гол сумын ЗДТГ, аймгийн Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын албан хаагчдад:

1. Харилцаа хандлага
2. Хувь хүний хөгжил
3. Байгууллагын соёл сэдвүүдээр сургалт явуулж байгууллага бүр өөрийн СОЁЛ-ыг тодорхойлж төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилт тавин ажиллаж байна. Байгууллагуудад Сумын Засаг даргын албан тоот хүргүүлсэн. Цахим хуудсаар дамжуулан “Байгууллагын соёлыг төлөвшүүлье” цуврал хичээлийг хүргэсэн.

СОЁЛЫН ЯАМ **ШАРЫН ГОЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВ**

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ БАЙДАЛ

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ

ҮНЭТ ЗҮЙЛ ИТГЭЛ ҮНЭМШИЛ **ХЭМ ХЭМЖЭЭ ДҮРЭМ ЖУРАМ**

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР

ДАРХАН-УУЛ АЙМАГ ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

45010 Шарын гол сум, Дархан-Уул аймаг
Утас: 7037-2528
E-mail: sharyngol_zdtg@yahoo.com

2022.11.26 № 4522
Танай _____ -ийн № _____ -т

ДАРГА ЗАХИРАЛ ЭРХЛӨГЧ НАРТ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Соёлын яамнаас хэрэгжүүлж буй “Соёлын бүтээлч сар” үйл ажиллагаанд дараах чиглэлээр оролцохыг үүрэг болгож байна.

1. Байгууллага бүр ажилтан албан хаагчдыг “Харилцаа-Хандлага” сургалтад хамруулах.
2. Байгууллагын соёл, үнэт зүйлийг тодорхойлж хэвшүүлэх.

Ажлын тайланг 11-дүгээр сарын 21-ний дотор ирүүлэхийг мэдэгдье.

ЗАСАГ ДАРГА **БАХАМСҮРЭН**

4522021144

Шарын гол сумын Соёлын төвийн номын сангаас 2 дугаар сургуулийн 6 дугаар ангийн багш нартай хамтран сурагчдад номын сангийн үйл ажиллагааг сурталчилж **“Сургамжит өгүүллэгээр ухаарахуй”** уншлагын аяныг өрнүүллээ.



Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Лувсанцэрэн овогтой Алтангэрэлийг сурталчлан алдаршууллаа. Тэрээр 1993.02.19-нд Монголын хамгийн ой ухаантай хүнээр шалгарч байсан. Хэдэн ч оронтой тоог нэмж, хасч, үржүүлж, хуваах үйлдлийг цээжээр тооны машинаас хурдан боддог. Аливаа зүйлийг он сар өдөр цаг минуттай нь цээжилдэг, мартдаггүй гоц авъяастай. Өөрийн гараар мод, төмөр болон бусад эд материалаар оюун ухаан сорьсон сонин содон оньсон тоглоом урладаг.

Монголын төдийгүй Дэлхийд ХОВОРХОН, ГАЙХАМШИГТАЙ хүмүүсийн төлөөлөл АМЬД ТООНЫ МАШИН гэж нэрлэгддэг НУТГИЙН БАХАРХАЛ болсон ӨВ ТЭЭГЧ болсон түүнийг өсвөр үе хүүхэд багачуудад таниулан, түүний тоо боддог аргад суралцуулах ажлыг 2 сургуультай хамтран явуулж байна.



“Талархлын орон зай” цахим аян өрнүүллээ.


Иргэдэд цахим орчны соёлтой хэрэглээг төлөвшүүлэн, хэн нэгэнд баярлаж явдаг бол түүнийгээ чин сэтгэлийн үгсээр холбон илэрхийлэх боломжийг олгож байгаа юм. Одоогоор 40 орчим хүнд талархал хүрээд байна.



Шарын голчууд бид өөрсдөдөө төлөвшүүлэх соёл юу вэ? Цахим хэлэлцүүлэг

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ БАЙДАЛ сэдвийн хүрээнд сумынхаа иргэдийн дунд цахимаар хэлэлцүүлэг явуулж, орон нутгийн онцлог, ахуй амьдрал, орчин нөхцөл, дэд бүтцийн хөгжил зэрэгтэй уялдуулан зайлшгүй төлөвшүүлэх соёлыг тодорхойлон төлөвшүүлэхэд энэхүү үйл ажиллагаа чиглэсэн болно.

Үндэсний нэгдмэл байдал - бахархал,омогшил:Хүн бүрт омогшил бардамнал зүрхний угт нь асах бахархал байдаг. Тэгвэл бид танд тэрхүү омогшил, бахархалаа тодоор илэрхийлэх боломжийг олгосон цахим уралдааныг зарласан.



Уран уншигч хүүхдүүдийг бэлтгэлээ

2 дугаар сургуулийн урлагийн наадамтай холбогдуулан номын санч өөрийн хичээллүүлдэг уран уншлагын “Яруу эгшиглэн” дугуйлангаар дамжуулан 5 хүүхэд бэлтгэн оролцууллаа.



ХОНГОР СУМЫН СОЁЛЫН ТӨВ: Соёлын бүтээлч сарыг Залуучууд театрын уран бүтээлчдийн “Алтан намар” урлагийн тоглолт, “Шидэт модны үр” хүүхдийн жүжгийг хүүхэд багачууд, иргэдэд үзүүлж үдшийн цэнгүүн зохион байгуулснаар эхлүүлсэн.

Сумын иргэд, тариаланчдын дунд “Караоке” тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээн 4 үе шаттай явагдаж аваргыг шалгарууллаа.



Соёлын бүтээлч сарын хүрээнд “Алтан намар” үйл ажиллагааны нэг төрөл болох гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээн нь тариаланч, ногоочид, хадланчдын дунд зохион байгуулагдаж 8 багийн 70 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин тэмцээндээ оролцлоо.

- ✚ 1-р байранд С.Мөнгөнцоож ахлагчтай “Түмэн буулай ХХК”
- ✚ 2-р байранд Г.Пүрэвбаатар ахлагчтай “Ургамал газар тариалангийн хүрээлэн”
- ✚ 3-р байранд Л.Өнөмөнх ахлагчтай “Баялаг капитал ХХК” тус тус шалгарлаа.



ОРХОН СУМЫН СОЁЛЫН ТӨВ: 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Залуучууд театр хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ "Шидэт модны үр" хүүхдийн жүжгийг хүүхэд багачууддаа толилуулсан. Үүнээс Сургуулийн өмнөх боловсролын 80 хүүхэд, Ерөнхий боловсролын сургуулийн 170 хүүхэд, нийт 250 хүүхэд багачууд үзэж сонирхлоо. Мөн сумын иргэдэд Залуучууд театрын “Алтан намар” уран бүтээлийн тоглолт тоглож, үдшийн цэнгүүн зохион байгуулав.

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын нэгдсэн тоглолт, Бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдааны бэлтгэл хангасан. 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр ЕБС-ийн ахлах ангийн 30 сурагчдад орон нутаг судлах танхимаа танилцуулж биет өв, биет бус өвийн талаарх ойлголт өгсөн.

Орхон сумын соёлын төв нь цахим судалгааны ажлыг эхлүүлж соёлын биет бус өвлөн уламжлагчдаа бүртгэсэн.



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САРЫН ХҮРЭЭНД “БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ” БУЮУ 2 ДАХЬ 7 ХОНОГТ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

ЗАЛУУЧУУД ТЕАТР: Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд Залуучууд театрын уран бүтээлчид ЕБС-ийн ахлах ангийн 150 сурагчдыг оролцуулан Театр сурталчлах өдөрлөг хийв. Тус өдөрлөгийн үеэр уран бүтээлийн 4 анги өөрсдийн мэргэжлийн талаархи мэдээ мэдээллийг хүргэж уран бүтээл хэрхэн бүтдэг талаар хүүхдүүдэд танилцуулж уран бүтээлийн дээжсээ өргөн барьяа. Тухайлбал:

Хөгжим ангийнхан өөр өөрийн хөгжмүүдээ танилцуулж хөгжим тус бүрээр хөгжим тоглов.



Бүжиг ангийнхан Монгол ардын бүжгийн тухай ойлголт өгч “Товшуурт”, “Аягатай дөрвөд”, “Сэдэн залуу” уран бүтээлүүдээ хүргэлээ.



Драм ангийнхан Залуучууд театрын ерөнхий найруулагч, МУСТА М.Цогтын найруулан тавьж байгаа “Нэр зээлдэгч” жүжгийн сургуулилтаас үзүүлж хэрхэн уран бүтээл бүтдэг талаар мэдээлэл хүргэлээ.



Дуу ангийн уран бүтээлчдээ танилцуулан тус бүрийн дуучдын хоолойн төрөл ангиллын талаар мэдээлэл хүргэж “Хамгийн сайхан хот”, “9 эрдэнийн орон”, “Бүүвэйн дуу” зэрэг уран бүтээлүүдээ хүргэлээ.

Соёлын бүтээл сарын хүрээнд Залуучууд театрын хөгжимчин, ая зохиогч МУСТА Т.Ган-Эрдэнийн бие даасан "Тэнгэрт тогтсон уулс минь" уран бүтээлийн тайлан тоглолтыг 400 гаруй үзэгчид үзэж сонирхлоо. Тус уран бүтээлийн тоглолтод Залуучууд театрын дуу, бүжиг, хөгжим ангийн 50 гаруй уран бүтээлчид оролцож үзэгчдийн халуун алга ташилтаар дүүрэн тоглолт болж өндөрлөлөө. Мөн тус тоглолтын лед дэлгэцээр гарах дүрс болон лед дэлгэцэн дээр маркетингийн албаны IT инженерийг суулгалаа.




Мөн Залуучууд театраас 11 дүгээр сарын 12-ны өдөр Өсвөр насны хүүхдүүдэд зориулсан “Open mic”, 11 дүгээр сарын 13-ны өдөр Дуучин, МУСТА О.Чингүнжавын “Зун болдог байх” уран бүтээлийн тоглолтыг зохион байгуулав.

Театрт хэрхэн соёлтой үйлчлүүлэх талаарх бяцхан үзэгчиддээ хүргэх зөвлөгөө хийж хөлтэй стикерт байрлууллаа.

Шинэ уран бүтээл МУСТА М.Цогтын найруулж буй "Нэр зээлдэгч" жүжгийн постер хийж сошиал сүлжээнд байршууллаа.

Залуучууд театрт 2022.11.21-ний 19:00 цагаас тоглогдох МУГЖ Даваасамбуугийн ДАГИЙСҮРЭНГИЙН "СОНГОДОГ ҮДЭШ" уран бүтээлийн тоглолтын зар мэдээллийг иргэдэд хүргэж тоглолтын бэлтгэл хангаж байна.

Мөн “Авьяаслаг төрийн албан хаагчид” урлагийн их наадам шүүгчдийн онооны самбар хийж ажиллалаа.



“Авьяаслаг төрийн албан хаагчид” урлагийн их наадам энэ сарын 11-нд дууны төрлөөр эхлэх тухай мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад хүргүүлээ.



Соёлын бүтээлч сарын хүрээнд Muugii's DANCE School хүүхэд залуучуудын дунд “Бүжгээр дархлаагаа дэмжье” challenge-ийг 2022 оны 11 дүгээр сарын 14-20 –ны өдрүүдэд зохион байгууллаа. Нийт 15 оролцогч давлагаанд нэгдсэн.

АЙМГИЙН МУЗЕЙ: “Соёлын бүтээлч сар”-ын II долоо хоногийн “Бүх нийтийн соёлын боловсрол” хүрээнд Музейн сан хөмрөгөөс “Дархан-Уул аймгийн Музейн урлагийн бүтээлүүд” уран зургийн үзэсгэлэнг 11 дүгээр сарын 07-20-ны өдрүүдэд дэглэлээ.

Монголын сор болсон Чүлтэм, Жамсран, Гаваа, Одон, Даваахүү, Цэрмаа, Сүхбаатар зэрэг олон уран бүтээлчдийн уран зураг, сийлбэр, уран баримал, зээгт наамал зэрэг бүтээлүүд дэглэгдэв. Уг үзэсгэлэнд 4 төрлийн 28 бүтээл дэглэгдсэн. Нийт 152, үүнээс том хүн 33, хүүхэд 119 урлагийн боловсрол авав.



“Дархан-Уул аймгийн Музейн урлагийн бүтээлүүд” түр үзэсгэлэнг Дархан-Уул аймгийн Шүүх Шинжилгээний албаны хамт олон үзэж, “Уран зураг уншихуй” боловсролын хөтөлбөрт хамрагдав.

Мөн Эмпати сургуулийн Б.Чаасамба багштай 6-б ангийн сурагчид урлагийн бүтээл талаас нь дэлгэрэнгүй тайлбартай үзэж, соёлын бүтээлч сарын аянд нэгдлээ. Мөн Мандала” боловсролын хөтөлбөрт хамрагдаж үзсэн мэдснээ бататгалаа.

Аймгийн Музей, Зураач, урчуудын эвлэл хамтран **"УРАН ДАРХАНЫ ХӨГЖИЛ, ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ"** түр үзэсгэлэнг 11 дүгээр сарын 11-ний өдөр толилууллаа. Нээлтэд аймгийн ИТХ-ын дарга С.Насанбат, аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, СУГ-ын дарга Х.Соёл-Эрдэнэ болон аймгийн Зураач Урчуудын Эвлэлийн зураачид, дугуйлангийн сурагчид оролцлоо. Үзэсгэлэнд уран дархан Д.Түмэнжаргал, С.Мөнхбаатар, Н.Мөнгөнбаяр нарын ур ухаанаар бүтээгдсэн 40 орчим орчин цагийн соёлын өвийн бүтээлүүд дэлгэгдсэн. Мөн үеэр МУСТА, уран дархан Д.Түмэнжаргал "Уран дарханы түүхэн хөгжил" сэдвээр ярилцлага хийлээ. Нэг өдөр дэлгэсэн тус үзэсгэлэнг 58 хүүхэд, 28 насанд хүрэгч нийт 86 хүн үзэж сонирхлоо.




“Дархан Музейн Урлагийн бүтээлүүд” ном нь 29 уран бүтээлчийн намтар, 62 урлагийн бүтээлийн тайлбар, мэдээлэл болон гэрэл зургаас бүрдсэн сургалт сурталчилгааны номын нээлт хийсэн.



ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОН: Сургагч багш-Номын санч мэдээллийн ажилтан С.Оюунцэцэг “Угийн бичиг хөтлөх арга” сэдвээр мэдээлэл бэлтгэж, өөрийн ордны пейж хуудсанд байршуулж, нийт 14465 хэрэглэгчдэд хүргэсэн байна.

<https://www.facebook.com/photo/?fbid=787075882459348&set=pcb.787018549131748>



Бага насны хүүхдүүдийг ХНО-ны үйл ажиллагаатай танилцуулах, ном унших сэдлийг төрүүлэх, номонд дуртай болгох, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэхэд хөтөч болох зорилгоор “Танилцах аялал”-ыг тогтмол зохион байгуулж байна. “Танилцах аялал”-д ЕБ-ын 9 дүгээр сургуулийн 3ж, 15 дугаар сургуулийн 2б ангийн сурагчид оролцож байнгын уншигч болж “Гоё үлгэр”, “Чавганы яс” зэрэг өгүүллэгээр чанга уншлага хийж харилцан ярилцав.

<https://www.facebook.com/photo/?fbid=786347855865484&set=pcb.786348262532110>



“Бүх нийтийн соёлын боловсрол” хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, номыг бүтээлчээр унших чиг хандлагад төлөвшүүлэх зорилгоор “Өглөөний кофетой уншлага”-ыг “Од” цогцолбор сургуулийн 10³ ангийнхантай хамтран зохион байгууллаа.

“Өглөөний кофетой уншлага”-аар сурагчид “BOOK & COFFEE” танхимд уншигчийн карт нээлгэн БЯМБА гараг бүрийн 15:00-аас тус танхимд баг хамт олноороо ном уншиж, бүтээлч ажлаа хамтарч хийж байхаар боллоо. Үйл ажиллагааны талаарх мэдээллийн өөрийн пейж хуудсандаа байршуулж, одоогоор 382 хэрэглэгчдэд хүрсэн байна.

<https://www.facebook.com/photo/?fbid=789521102214826&set=pcb.789528598880743>



“Соёлын бүтээлч сар”-ын бүтээлч ажлын хүрээнд төрөлжсөн танхимын номын санчид хамтран Хүүхдийн номын ордны лого, номын тухай онч мэргэн үг бүхий 50 ширхэг номын хавчуургыг хийж, уншлага үйлчилгээ, бэлэг дурсгалд ашиглаж эхлээд байна.



Хүүхдийн номын ордон: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд хүүхэд багачуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, номонд дуртай болгох, номоор дамжуулан өөрийгөө хөгжүүлэх, ном унших арга зүйд төлөвшүүлэх, идэвхтэн уншигчдын тэргүүн туршлагыг бусадтай хуваалцах, урамшуулах зорилгоор “Уншихад урам хайрла” цуврал видео контентийн 5 дах дугаарыг бэлтгэн өөрийн пейж хуудсанд байршуулсан. Энэ удаагийн контентод салбар номын сангийн идэвхтэн уншигч эгч дүү М.Хүслэн, М.Халиун нар оролцов. /Хүрсэн хэрэглэгчдийн тоо 1269/



АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН: Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгт “Зурагт ном” өдөрлөг зохион байгуулж нийт бага, дунд, ахлах, бэлтгэл 6 бүлгийн үлгэрч хүүхдүүд оролцлоо.



Төв номын сангаас Онцгой Байдлын газрын албан хаагчдад соён гэгээрүүлэх лекц хийв. Лекцээр:

- "Жаргалант Дархан" ТББ-ын Тэргүүн, Гэр бүл судлаач Б.Дэмбэрэлмаа "Гэр бүлийн үнэ цэн- Ёс заншил" лекц
- Аймгийн Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд "Тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах тухай" мэдээлэл
- Хувь хүний хөгжил сэдэвт 110 боть номоор 15 минутын уншлага хийж мэдээ мэдээллийг тус тус хүргэлээ.

Соён гэгээрүүлэх ажилд танхим болон цахим хосолсон нийт 120 гаруй алба хаагч оролцлоо.



Аймгийн Хүүхдийн зөвлөлийн гишүүд 2 дахь долоо хоногтоо Төв номын санд "Номын эмч" хийлээ. Сурагчид хүүхэд, залуучуудад зориулсан Англи хэлний 1000 орчим номонд уут хийж, ангилан ялгаж, техник ажиллагаанд бэлэн болгож өгөв.



Монгол хүний үнэт өв, үндэсний дархлаа болсон үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад сурталчлан таниулах, хэл бичгийн бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор соёлын бүтээлч сарын хүрээнд "Монгол бичиг - Монгол бахархал" түргэн уншлагын уралдаан зохион байгууллаа. Уралдааныг ЕБС-ийн есдүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулж, найман сургуулийн 88 сурагч оролцож өгөгдсөн сэдвүүдээс минутын уншлага хийсэн.

Уншлагын нийлбэр дүнгээр 18 дугаар сургуулийн есдүгээр ангийн Б.Анударь тэргүүлсэн бол удаах болон шагналт байруудад "Оюуны-Ирээдүй" цогцолборын 9-13 ангийн сурагч Ж.Хүслэн, есдүгээр сургуулийн сурагч Г.Даваадулам, Б.Анхзаяа, Г.Тэлмэн нар шалгарав. Түргэн уншлагын уралдаанд үндэсний бичгээр хэвлэн гардаг "Хүмүүн бичиг" сониныг ашигласан .



“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Хонгор сумын Соёлын төвөөс Аймгийн Төв номын сантай хамтран нийт Номын санчдын дунд Караоке тэмцээнийг зохион байгууллаа.



ШАРЫН ГОЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВ: ЕБ-ын 2 дугаар сургуулийн бага, дунд, ахлах ангийн 45 бүлгийн 1387 хүүхдийн дунд зохиогдсон “УРЛАГИЙН ИХ НААДАМ”- д хөгжим техникийн дэмжлэг үзүүлж шүүгчээр ажилласан. /Дарга бүжгийн багш 2/. Ингэснээр хүүхдийн авьяас чадварыг нээн илрүүлэх, цаашид хөгжүүлэх, харилцан бие биенээсээ суралцах, урлагийн төрөл зүйл таниулах, гоо зүйн төлөвшил олгохоос гадна сумынхаа авьяастны тоог нэмэгдүүлэх боломж нээгдэж байгаа юм.



Номын сангийн дэргэд хичээллэж буй уран уншлагын “Яруу эгшиглэн” дугуйлангийн 5 сурагчаас **“СУРГУУЛИЙН УРЛАГИЙН ИХ НААДАМ”**-ын уран уншлагын төрөлд 2 хүүхэд тэргүүн, 1 тэргүүн дэд байранд шалгарав.

Мөн **“БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ”** цахим цуврал хичээлийн 6 дахь нийтлэлийг орууллаа. **“ОЮУНЛАГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ”** аянд төрийн байгууллагын 2 албан хаагч нэмж нэгдсэн бөгөөд 4 номоор үйлчлүүлсэн. Сумын иргэд, хүүхэд багачуудын дунд зарласан **“МИНИЙ ОМОГШИЛ БАХАРХАЛ”** сэдэвт цахим илтгэлийн уралдаанд Шарын гол сумын Засаг дарга болон **31** иргэнээс бичлэг ирүүлсэн. **“ТАЛАРХЛЫН ОРОН ЗАЙ”** цахим давлагаанд нийт **33** хүн нэгдсэн. **“ШАРЫН ГОЛЧУУДАД ТӨЛӨВШҮҮЛЭХ СОЁЛ”** цахим хэлэлцүүлэгт **9** иргэн өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн.

Соёлын төв, МЗЭ-ийн Дархан салбарын зохиолчдын төлөөлөл, Шарын гол сумын “Яруу эгшиглэн нэгдэл хамтран зохиолч яруу найрагчдын уулзалт өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт орон нутгийн төрийн байгууллагуудын 5 удирдлага уригдан оролцож зохиолчдод хүндэтгэл үзүүллээ. Соёлын төвийн залуу дуучин С.Март, болон ахмад уран бүтээлчид мэндчилгээ дэвшүүлсэн. Уг арга хэмжээнд нийт 38 хүн оролцож, уран үгсийн чуулган дор нэгдэн цэнгэж тулгамдаж буй асуудал болон цаашдын хамтын ажиллагааны талаар халуун яриа өрнүүлснээс гадна, шинэ залуу үеийн төлөөллөөр шинэхэн даргаа сонгон томиллоо.



Ажилтан албан хаагчдад нийтийн бүжиг зааж сургах сургалтыг бүжгийн багш Б.Болортуяа сумын Ахмадын хорооны ахмад настан Н.Цэцэгмаатай хамтран явуулж байгаа бөгөөд сургалтад ЗДТГ-ын 26 албан хаагч, Шарын гол сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс-10 албан хаагч, АГУ 55 дугаар ангиас 14 албан хаагч, 2 дугаар сургуулийн 11 хүн хамрагдлаа.



ХОНГОР СУМЫН СОЁЛЫН ТӨВ: Хонгор сумын Соёлын төвөөс орон нутаг судлах танхим, нийтийн номын сан, хөгжим, бүжгийн спортын мэдлэгийг иргэдэд олгох зорилгоор 7 хоногт 2-оос доошгүй мэдээллийг цахимаар нийтэлж хэвшсэн.

Хонгор сумын тариаланчид, ногоочид, хадланчдын дунд “Алтан намар” сэдэвт намар цагийн хаалт, өвөл цагийн нээлтийн 3 үйл ажиллагааны хаалтын концерт 2022 оны 11 дүгээр сарын 4-нд Гүнж ресортод зохион байгуулав. Нийт 120 гаруй тариаланч, хадланч, ногоочид оролцлоо. Тус концертод Дархан-Уул аймгийн ХХААГ-ын дарга Т.Ганболд, Хонгор сумын сумын ИТХ-ын дарга Н.Ганбаатар, сумын Засаг дарга Т.Атархишиг нар урилгаар оролцож зочид төлөөлөгчдөд хандан мэндчилгээ дэвшүүлсэн. Мөн үеэр Дархан-Уул аймгийн дээд шагнал болох

“Найрамдлын дархан” тэмдгээр 3 иргэн,

- “Тэргүүний ажилтан” тэмдгээр 3 иргэн,
- “Аймгийн Засаг даргын жуух бичиг” 3 иргэн,
- “Сумын засаг даргын жуух бичиг” 5 иргэн,

Караоке тэмцээнд:

- 1-р байр Ю.Гомбосүрэн ахлагчтай “K700” баг
- 2-р байр С.Мөнгөнцоож ахлагчтай “Алтан тариа” баг
- 3-р байр Н.Алтантуяа ахлагчтай “Ахмадын золбоо” баг

Волейболын тэмцээнд:

- 1-р байранд С.Мөнгөнцоож ахлагчтай “Түмэн буудай ХХК” баг
- 2-р байранд Г.Пүрэвбаатар ахлагчтай “Хүрээлэн -1 дүгээр” баг
- 3-р байранд Л.Өнөмөнх ахлагчтай “Баялаг капитал” багууд тус тус шалгарч шагналуудаа гардан авлаа.

Мөн Залуучууд театрын уран бүтээлч, МУСТА Бибиш, МУСТА Галмандах, Соёлын төвийн Эрхлэгч Г.Сайхансанаа, хөгжмийн багш Б.Асалбек мөн чөлөөт уран бүтээлчид ая дууны мэндчилгээ дэвшүүлж ажиллалаа.



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР: "Мэдлэг ур чадвартай төрийн албан хаагч" төсөл, "Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд "Авьяаслаг төрийн албан хаагч" урлагийн их наадмыг Дархан-Уул аймгийн ЗДТГ, Соёл, урлагийн газар, Залуучууд театр хамтран зохион байгуулж байна.

Тус наадмын Дуу, бүжгийн төрлийн шалгаруулалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11, 12-ны өдөр хийв. Наадамд аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын албан хаагчид оролцож байна. Шүүгчээр аймгийн Залуучууд театрын мэргэжлийн уран бүтээлчид ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 18, 19-ний өдөр ХӨГЖИМ- /2 төрөл/, БУСАД -/3 төрөл/ гэсэн төрлүүд явагдана.





TEDxDarkhanwomen олон улсын лиценз бүхий арга хэмжээг аймгийн Эмэгтэйчүүдийн холбооноос санаачилан зохион байгуулсан. Тус арга хэмжээнд аймгийн Соёл, урлагийн газар, Залуучууд театр хамтран зохион байгуулагчаар оролцов. Илтгэлийн эхлэл, дунд, хаалт хэсэгт Залуучууд театрын уран бүтээлчид уран бүтээлийн тоглолт толилуулж, аймгийн Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ TEDx ярилцлагыг хөтлөн явууллаа. Тус арга хэмжээнд 500 гаруй иргэд оролцлоо.




Дархан-Уул аймгийн Зураач урчуудын эвлэлийн гишүүн, зураач Э.Номинбат TEDxdarkhanwomen-ы олон улсын үйл ажиллагааны илтгэгч нарт Талархал илэрхийлэх үйл ажиллагааны үеэр зургийн үзэсгэлэнгээ толилууллаа.



Дархан-уул аймгийн Ахмадын дунд “ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫН НААДАМ” 2022 оны 11 дүгээр сарын 10 - 2022 оны 11 дүгээр сарын 30 –ны хооронд болохтой холбогдуулан удирдамжийг боловсруулж, мэдээллийг олон нийтэд хүргэсэн.



Соёлын яамнаас зохион байгуулсан "Соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, уламжлалт гар урлалыг дэмжин хөгжүүлэх боломж шийдэл - 2022 нэгдсэн арга хэмжээнд 1000 гаруй урлаачдын 2000 бүтээл оролцсноос Дархан-Уул аймгийн оролцогч "Цайны их зам" ХХК-ийн үйлдвэрлэдэг ширэн эмээлүүд "ШИЛДГИЙН ШИЛДЭГ" бүтээгдэхүүнээр шалгарлаа.



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САРЫН ХҮРЭЭНД СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ БУЮУ 3 ДАХЬ 7 ХОНОГТ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР: "Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд зохион байгуулж буй "Соёлын өв-Тогтвортой хөгжил" соёлын өвийн улсын хоёрдугаар зөвлөгөөнд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр аймгийн Соёл, урлагийн газрын дарга, Соёлын өвийн мэргэжилтэн нар цахимаар оролцлоо. Энэхүү зөвлөгөөн Монгол үндэстэн, угсаатны үнэт зүйлс болох соёлын өвд түшиглэсэн соёл, аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийн орон зайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг бий болгох зорилготой юм.

Соёлын бүтээлч сарын хүрээнд аймгийн Соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Ахмадын хөгжлийн төв хамтран ахмад настны өвлөн уламжлагчдын наадмыг зохион байгуулж байна. 2022 оны 11 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд Ерөөлч, Магтаалч, Бөх цоллооч, Морь цоллоочдын уралдааныг зохион байгууллаа. Шүүгчээр МУ болон Монголын үйлдвэрчний эвлэлийн СТА, АБТА Д.Дашзэвэг, МУСТА, Улсын Крөөлч магтаалч, хуурч Ц.Дүйнхэрсүрэн, МУ-ын Үндэсний өв соёл цоллоочдын холбооны тэргүүн, Улсын морь бөх цоллооч, МУСТА, Ерөөлч магтаалч Б.Дарханнам, Соёл, урлагийн газрын Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Энхбаяр нар ажиллалаа.



ЗАЛУУЧУУД ТЕАТР: “Соёлын бүтээлч сар”-ын 3 дахь 7 хоногийн хүрээнд Залуучууд театрын Үндэсний найрал хөгжмийн уран бүтээлчид “Дархан хотын “Номин” худалдааны төв, “Оргил” худалдааны төвийн үйлчлүүлэгч болон түрээслэгч нарт уран бүтээлийн дээжсээ өргөн барьж уран бүтээлээ сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулан явууллаа.



Залуучууд театрын шинэ уран бүтээл МУСТА М.Цогтын найруулсан “Нэр зээлдэгч” жүжгийн хэвлэлийн бага хурал зарлаж, цахим хуудсаараа сурталчиллаа.

Соёлын бүтээлч сарын хүрээнд Залуучууд театрын төлөвлөгөөт уран бүтээл ОХУ-ын нэрт жүжгийн зохиол Лев.Корсункийн зохиол найруулагч МУСТА М.Цогт “Нэр зээлдэгч” инээдмийн жүжгийн постерийн зургийг “Эхлэл” гэрэл зургийн студитээр авхууллаа.



“Нэр зээлдэгч” инээдмийн жүжгийн радиогийн хоолойн бичлэг хийлгэж 89.1, 107.5, радиод цацууллаа.



МУЗЕЙ: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд толилуулсан Дархан-Уул аймгийн Музейн урлагийн бүтээлүүд түр үзэсгэлэнг “Эмпати” сургуулийн О.Шингис багштай 8-б ангийн сурагчид урлагийн бүтээл талаас нь дэлгэрэнгүй тайлбартай үзэж, “Соёлын бүтээлч сар”-ын аянд нэгдлээ.



Музейн “Мандала” боловсролын хөтөлбөр ЕБС-ийн ангиудад очиж сурагчдад боловсролын үйлчилгээг хүргэлээ. Энэ долоо хоногт ЕБ-ын 9 дүгээр сургуулийн Цогзолмаа багштай 8в ангийн 40 сурагч соёлын бүтээлч сарын аянд нэгдлээ.



Аймгийн Төв номын санд хятад хэлний сургалттай “Цайхун” сургуулийн 5а ангийн сурагчид 14 хоногт нэг удаа ангиараа ном уншиж, уншсан номын тэмдэглэл хөтлөх “Номтой нөхөрлөө” ажлыг зохион байгуулдаг уламжлалтай. Уламжлалын дагуу тус ангийн сурагчдад үйлчилж, соёлын бүтээлч сарын үйл ажиллагааг танилцуулав.

ТӨВ НОМЫН САН: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Философич С.Молор-Эрдэнийн номын танилцуулга, лекцийг зохион байгуулав. Философийн ухааны доктор С.Молор-эрдэнийн Цуврал 3 ном буюу ном доторх номын агуулга нь Эрх чөлөө -Эрхэм үг, Тэгш эрх -Тэгш боломж, Шударга ёс - Шударга нийгэм болон Монголын өнөөдөр, маргааш, өчигдөр зэргээс бүтдэг. Философич маань тус номын нээлт, утга агуулга хийгээд Монгол хүн нийгэмд эрх чөлөөтэй юу, эр эм хосууд хоорондоо тэгш эрхтэй юу болон боловсрол яриад буй хүмүүс шударга ёсыг эрхэмлэдэг үү зэрэг олон асуултуудад хариулан эрх чөлөөгөө шалгаж, тэгш эрхээ хамгаалж, Монгол хүн мөн чанараа олох цаг дор соён гэгээрлийн ажлуудаа орон нутгуудад хийж яваа юм.



Аймгийн Төв номын сангийн зүгээс "Монгол урлал" сургалт, үзэсгэлэн худалдааг Эмэгтэйчүүдийн ордон, Дархан сумын Ахмадын хороотой хамтран зохион байгуулав.

Соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчид цуглаж Монгол хүний үнэт хэрэглээ болсон даалин, хөөрөг хэрхэн урлах, хэрхэн хэрэглэх талаарх мэдээ мэдээллийг өгч, зүү ороох хатгамалыг зааж, үзэсгэлэн худалдааг гаргалаа.

Өнөөдрийн үйл ажиллагаанд Төв номын сангаас "Монгол урлал" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргасан ба "Чамин хээ", "Сэтгэмж" урлан, Хөөрөг урлаач Б.Бямбаа, даалин урлаач А.Золжаргал, оёдол эсгүүрчин Д.Давааням, Зүү ороох хатгамал урлангийн багш Д.Амарбаясгалан болон бусад соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчид оролцож, даалин хөөрөг сонирхогчид сургалт мэдээлэл авч, худалдан авалт хийв.



ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОН: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд “Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн”-ний болзол хангасан Од цогцолбор сургуулийн Б.Энхмаа багштай 5-1 анги хамт олны бүтээлийн үзэсгэлэнгээ гаргаж, Их зохиолчийн уран бүтээлээс театрчилсан тоглолт үзүүлэн шүлэг найраглал, өгүүллэгээс нь уншиж, үе тэнгийн уншигч хүүхдүүддээ ном унших чиг хандлага, ном унших арга зүйд хэрхэн суралцаж байгаа талаараа туршлага хуваалцлаа.



Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан Хүүхэд багачуудын авьяас билиг, зохион бичих ур чадварыг хөгжүүлэх, дэмжин урамшуулах, өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх зориолгоор ЕБ-ын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг оны шилдэг шүлэг шалгаруулах “Найргийн даага” уралдааныг 2 насны ангилалтай, 2 шаттай зохион байгуулж, 11-р сарын 17-нд ангилал тус бүрээс 2 дугаар шатанд шалгарсан 10 найрагч хүүхдүүд шүлгээ уншиж, дүнгээ гаргаж ажиллалаа.



ШАРЫН ГОЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВ: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Шарын суманд үйлдвэрлэл үйлчилгээ, брэнд баялаг бүтээж байгаа олонд танигдаагүй үйлдвэрлэл эрхлэгчдийг судлан илрүүлж, иргэдэд сурталчлан таниулан, цаашдын бизнес үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, орон нутгийн удирдлагад танилцууллаа.

18 баялаг бүтээгч нийтэд танилцуулсан. “EDEN” брэндийг үүсгэн байгуулагч иргэн Э.Ариунзул.



Н.Насанжаргал эрхлэгчтэй “Хүннү мөр” брэндийн гутлын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилалаа. 29000 хүн үзсэн.



ХОНГОР СУМЫН СОЁЛЫН ТӨВ: Хонгор сумын 1, 2 дугаар багт амьдардаг соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 7 ахмад уран сайханчийг цахимаар сурталчлав.



Төрийн албан хаагчдын дунд зохион байгуулагдаж буй "Авьяаслаг төрийн албан хаагчид" тэмцээнд Хонгор сум багийн нийт дүнгээр 207 оноотой 1 дүгээр байранд жагсаж байна. Үүнд:

- Гоцлол дууны төрөлд Соёлын төвийн Эрхлэгч Г.Сайхансанаа I байр
- Дуэт дууны төрөлд Соёлын төвийн хөгжмийн багш Б.Аселбек, номын санч Янгиржав Цэцгээ I байр
- Хамтлаг дууны төрөлд Эрхлэгч Г.Сайхансанаа, Б.Асалбек, ЗДТГ-ын Газрын даамал Б.Гантуяа нар III байр тус тус эзэллээ. Хамтлаг бүжгийн төрөлд ЗДТГ-ын албан хаагчид, Соёлын төвийн ОНСТА ДүүрэнЗаяа Гоцлол бүжгийн төрөлд Хөгжмийн багш Асалбек Б. нар тус тус оролцлоо.

Гайхамшигт цирк 2022 оны 11 дүгээр сарын 16-нд 17:00 цагаас Соёлын төвд тоглодох реклам сурталчилгааг цахим хуудсаараа сурталчиллав.



ОРХОН СУМЫН СОЁЛЫН ТӨВ: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 16-ний өдөр “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР” аяны хүрээнд хүүхдүүдэд чиглэсэн “OPEN MIC” амжилттай зохион байгуулагдлаа ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн нийт 36 сурагч идэвхтэй оролцлоо.



2022 оны 11 дүгээр сарын 15-ний өдөр ЕБС-ийн сурагч нарын дунд “УРАН УНШЛАГА” шүлгийн тэмцээн анги хамт олноороо болон ганцаарчилсан төрлөөр нийт 29 сурагч оролцсоноос 3 байр эзлүүлж амжилттай зохион байгууллаа.



Соёлын бүтээлч сарын хүрээнд Бүжгийн дугуйлан долоон хоногийн 2, 4 дэхь өдрүүдэд өглөө, орой гэсэн хоёр ээлжээр нийт 65 бага дунд бүлгийн сурагч нар хичээллэж байна. Мөн 2022 оны 11 дүгээр сарын 18-нд болох “Авьяаслаг төрийн албан хаагч” урлагийн наадамд оролцсон.



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САРЫН “СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ” БУЮУ 4 ДЭХ 7 ХОНОГИЙН АЖЛЫН ТАЙЛАН

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР: “АВЬЯАСЛАГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД” Урлагийн их наадам 11 дүгээр сарын 19-нд сүүлийн өдрөө зохион байгуулагдаж амжилттай дууслаа.

Аймгийн ЗДТГ, Соёл урлагийн газар, Залуучууд театр хамтран зохион байгуулсан тус наадамд төрийн 30 гаруй байгууллагын хамтарсан 11 баг оролцож авьяас, ур чадвараа сорилоо.



Зураач урчуудын эвлэлтэй хамтран “ШИНЭ САЛХИ” уран зургийн үзэсгэлэн 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 11 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл Залуучууд театрт зохион байгуулав.



УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлангийн санаачилгаар хэрэгжүүлж буй “ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ, ОРОЛЦООТОЙ АМЬДРАЛ” хөтөлбөр, Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулж буй өвлөн уламжлагчдын наадам Бий биелгээний төрлөөр үргэлжилж байна. Ганцаарчилсан бий биелгээний төрөлд 12 оролцогч, хамтлаг төрөлд 5 баг амжилттай оролцож ур чадвараараа өрсөлдлөө.

Биелгээ нь олон ястны түүх, уламжлал, заншил, дуу хөгжим, үлгэр домог, туульс, хувцас өмсгөл, тоглоом наадам зэргийг өргөн утгаар нь өөртөө цогцлоон багтааж уламжлагддаг ба үндэстэн, ястнуудын амьдрал, өвөрмөц ахуй байдал, ёс заншил, уламжлал, сэтгэлгээний онцлогийг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх бүжгийн урлаг юм. Биелгээг гэрт, тойрон суусан хүмүүсийн дунд, зай багатай газар бүжиглэдэг байснаас цээж гарын хөдөлгөөн нарийн хөгжсөн бөгөөд Монгол хүний ажил үйлс, зан үйл, хэв шинж, амьдралын агуулгыг биелээч хүний сэтгэлийн хөдлөл, уран намбаар биелж харуулдаг.



ЗАЛУУЧУУД ТЕАТР: Монгол Улсын гавьяат жүжигчин Даваасамбуугийн Дагийсүрэнгийн “СОНГОДОГ ҮДЭШ” уран бүтээлийн тоглолт болов. Тус тоглолтод МУ-ын АЖ Б.Жавзандулам, Н.Мөнхшүр, Д.Самбуу, МУ-ын УГЗ Ч.Буянхишиг, МУГЖ Ц.Төвшинтөгс, Ц.Үенч, Д.Баасанжав, Г.Алтанцэцэг, Шархүү, Б.Нарантуяа, Бямбасүрэн, С.Соёл-Эрдэнэ, Б.Тунгалаг, МУСТА Б.Соронзонболд, П.Одонтунгалаг, Б.Чулуунчимэг, С.Зоригт, Б.Дэлгэрбаяр, Г.Энхнаран, Э.Очирсайхан, Б.Бат-Эрдэнэ, Дуучин Г.Дэлгэрболд нар хүрэлцэн ирж оролцлоо. Мөн Залуучууд театрын уран бүтээлчид болон Д.Дагийсүрэн гавьяатын шавь нар нь ая дуугаа өргөсөн юм. “СОНГОДОГ ҮДЭШ” уран бүтээлийн тоглолтыг Дархан хотын 450 гаруй иргэд үзлээ.



АЙМГИЙН МУЗЕЙ: IV долоо хоногийг “Соёлын аялал жуулчлал” үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлууд:

Дархан-Уул Дархан, Хонгор, Шарын гол сумдын түүх соёлын дурсгалт газруудтай танилцах аялалыг Музейн захирал Д.Жамбалдорж Дарханы уугуул иргэдтэй хамтран зохион байгуулав. Тус аялалаар Хонгор сумын Зулзага, Хүйтэний, Мухарын гол, Шарын гол сумын түүх соёлын дурсгалт газруудтай танилцаж аялснаас гадна орон нутгийн тахилгат хайрхан уулсын зургууд авч баримтжуулан судалгаа хийлээ. Эдгээр байгаль, түүх соёлын дурсгалт газруудын түүх, гэрэл зургуудыг цагаан сарын өмнө гарах “Дарханы Нэвтэрхий Толь” номонд оруулах боломж бүрдэв.



Дархан-Уул аймгийн Онцгой Байдлын Газраас зохион байгуулсан Төвийн бүсийн чуулганд оролцож буй Улаанбаатар, Эрдэнэт, Сэлэнгэ аймгийн Онцгой Байдлын Газрын Мэргэжилтнүүд “Соёлын бүтээлч сар” аянд нэгдэж “Дархан-Уул аймгийн Музейн урлагийн бүтээлүүд” үзэсгэлэнг үзэж танилцав. Мөн Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн тамгын газрын захиргааны албан хаагчид 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 11:00 цагт музейн сан хөмрөгтэй танилцлаа. Түр үзэсгэлэнг “Эмпати” сургуулийн О.Шингис багштай 8-б ангийн сурагчид урлагийн бүтээл талаас нь дэлгэрэнгүй тайлбартай үзэж, “Соёлын бүтээлч сар”-ын аянд нэгдлээ.



ЕБ-ын 9 дүгээр сургуулийн Цогзолмаа багштай 9д ангийн хамт олон нэгдэж “Үйчүүр, Хорло” боловсролын хөтөлбөрт хамрагдав. Нийт 62 үзэгч, үүнээс төлбөртэй 18, төлбөргүй 44, насанд хүрэгч 16, хүүхэд 46 зочилж тайлбарт үйлчилгээ авсан байна.

Их эзэн Чингис хааны мэндэлсэний 860 жил, "Монгол бахархлын өдөр"-ийг угтан 1-р сургуулийн Адьяасүрэн багштай нийгмийн сонгоны ангийн 24 сурагчид "Монголын Их Хаад" музейн боловсролын хөтөлбөрт хамрагдлаа. Ахлах ангийханд зориулсан тус хөтөлбөрөөр алтан ургийн 37 хаадын түүхтэй танилцан "Оюуны зангилаа" үгийн сүлжээ бөглөн мэдлэгээ сорилоо.



“Соёлын бүтээлч сар” аянд нэгдэн 29-р цэцэрлэгийн Бэлтгэл А, Б бүлэг, Шинэ алхам сургуулийн 2а, б бүлгийн хүүхэд багачууд түүх, өв соёлтойгоо танилцлаа.



ТӨВ НОМЫН САН: "ХОТЫН БҮТЭЭЛЧ АЯЛАЛ" зохион байгуулав.

Төв номын сангийн зүгээс орон нутгийн номын санчдаа мэргэжил арга зүйгээр ханган ажилладаг бөгөөд аймгийн хэмжээнд нийт 60 гаруй номын санч ажилладаг. "Соёлын аялал жуулчлал" 7 хоногийн хүрээнд номын санчдын "Хотын бүтээлч аялал"-ыг Аймгийн Төв номын сангаас зохион байгуулж байгаа бөгөөд аяллын эхний өртөө маань Ахмадын хөгжлийн төв байлаа. Жишиг төв болон хөгжиж буй тус төвийн үйл ажиллагаа, номын сантай танилцаж, өдрийн хоол идэж, хувь хүний хөгжлийн "ЭЕРЭГ СЭТГЭЛГЭЭ" сургалтыг авч үр бүтээлтэй аялал өрнөж байна.



ШУТИС-ийн харьяа Дархан Технологийн сургуулийн номын сан нь мянга орчим оюутанд үйлчилдэг, 36.0 орчим боть ном, 3 уншлагын танхим, бие даалтын 5 өрөөтэй. Оюутан сурагчид, багш нарын санаачлагаар 2 удаагийн төсөл хэрэгжиж чөлөөт сонголттой танхим болон уншлагын танхимаа тохижуулжээ. Мөн номын санчдын эрхлэн гаргаж буй "Би ДАТС-ийн оюутан" цахим сонин 3 дахь дугаараа гаргах гэж байгаа юм байна. Мөн Дархан-Уул аймгийн музейгээр аялж, аймгийнхаа түүх дурсгалт газрууд, болон үнэт ховор үзвэрүүдтэйгээ танилаа.



ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОН: Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр "Монгол бахархалын өдөр"-ийг тохиолдуулан төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг гүнзгий судалж, танин мэдэх зорилгоор ЕБС-ийн 7-8 дугаар ангийн сурагчдын дунд асуулт хариулт танин мэдэхүйн "Алтан хонх" уралдааныг зохион байгууллаа.

Үүнд.

- ✓ Тэргүүн байрт 16 дугаар сургуулийн 8а ангийн сурагч А. Анхтуяа
- ✓ Дэд байрт 16 дугаар сургуулийн 8а ангийн сурагч Б. Баярцэцэг
- ✓ Гутгаар байрт 15 дугаар сургуулийн 8б ангийн сурагч М. Номин-Эрдэнэ нар шалгарлаа.



Монгол наадгайн төрөл болох хүүхдийн оюун ухаан, сэтгэн бодох, зохиомжлох чадварыг хөгжүүлэх, эв найрамдал, нөхөрлөлийг бэлэгддэг "Эв долоо" тоглоомыг хүүхэд багачуудад сурталчлах зорилгоор Од цогцолбор сургуулийн 4-10 ангийн хамт олны хуваарьт уншлагыг "Эв долоо" тоглоомоор зохион байгуулж дүрс эвлүүлж тоо, амьтан, байшин зэргийг бүтээж авхаалж самбаагаа сорин суралцав.

ХУВААРЬТ УНШЛАГА

Од цогцолбор сургуулийн Э. Мигмаржаргал багштай 4-10 ангийн оюунлаг сурагчдын дунд СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ- МОНГОЛ НААДГАЙН ТӨРӨЛ ЭВ ДОЛОО-г таниулан сурталчлах зорилгоор эвлүүлж, нийлүүлэн дүрс, тоо, амьтан, байшин бүтээж авьяас, авхаалж самбаагаа сорьж уралдан цагийг хөгжилтэй, үр бүтээлтэй өнгөрүүлсэн та нартаа амжилт хүсье.

Эзэн нь хичээвэл Заяа нь хичээнээ гээд шашид энэ ардын наадмаа гэр бүл, найз нөхөдтэйгээ тоглож байгаарай гэж зөвлөе.

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ- МОНГОЛ НААДГАЙН ТӨРӨЛ ЭВ ДОЛОО

Сорж санал ТҮҮХ
Сэтгэн ариусгах УРЛАГ
Хуунийг гэгээрүүлэх СОЕЛ

2022.11.01-2022.11.30

Соёлын биет бус - Монгол наадгайн төрөл Эв долоо тоглоом

Зорилго нь: Монголчууд эрт цагаас энэ тоглоомоор үр хүүхдээ тоглуулж, оюун ухааныг нь хөгжүүлж, эв найрамдал, нөхөрлөлийг бэлгэдэн анх бүтээжээ.

Бүтэц: 7 хэсэг эв хавгүй өөдөө болон модноос бүрддэг.

Ач холбогдол нь:

- ✓ Эвлүүлж бүтээх гарын ур дүйтэй болно.
- ✓ Өнгө ялгаж сурна.
- ✓ Тоглоомонд хэвтэж, хөвчнөж сурна.
- ✓ Бүтээлээр сэтгэж, шинэ боломжуудыг эрж хайдаг болно.
- ✓ Бүтээсэн зүйлээ тайлбарлан ярьдаг болно.
- ✓ Аливаа юманд тэвчээртэй хандана.
- ✓ Цагийг үр бүтээлтэй ашиглаж сурна.

Монгол бахархалын өдрийг тохиолдуулан Цэцэрлэгийн насны хүүхэд багачуудыг номоор дамжуулан төлөвшүүлэх, ой тогтоолтыг сайжруулах, бүтэн өгүүлбэрээр ярьдаг болгох, эх хэлээ төгс эзэмших, өөрийгөө илэрхийлэх болон бусдыг сонсох цогц чадвар суулгах хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор уламжлал болгон зохион байгуулдаг “Чанга уншлага” арга хэмжээг 11 дүгээр сарын 22, 23-ний өдрүүдэд 29 дүгээр цэцэрлэгийн дунд, ахлах, бэлтгэл 5 бүлгийн 80, 4 дүгээр цэцэрлэгийн бага А бүлгийн 29, нийт 110 гаруй бяцхан хүүхдүүдэд зохион байгууллаа.

Чанга уншлагаар Од цогцолбор сургуулийн Э. Мягмаржаргал багштай 4-10 ангийн эцэг эхчүүд, багш нарын хийсэн “Гурван торой” хормогчин ном, “Цэцэн туулай” том номыг уншлаа. Мөн ХНО-ны сан хөмрөгт байдаг бага насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон зурагт номуудаар үзэсгэлэн гаргаж, хүүхэд багачуудад танилцуулж, уншиж өгсөн.





Алслагдсан сургуульд номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор “Бид ирлээ” аяны “Номтой өдөр” арга хэмжээний хүрээнд ЕБ-ын 1-р сургууль дээр нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэж ажиллаа. Үүнд:

- ✓ Шинэ оны карт хөнгөлөлтэй үнээр нээх;
- ✓ Бага ангийн сурагчдад нас сэтгэхүйн онцлогт тохирсон үлгэр, өгүүллэгээр чанга уншлага хийх;
- ✓ Номын санд шинээр ирсэн номын танилцуулга, тойм яриа хийх;
- ✓ Дунд, ахлах ангийн сурагчдын дунд шинжлэх ухаан, танин мэдэхүй, уран зохиолын номуудаар уншлага хийх зэрэг ажлууд зохион байгуулж, нийт 255 гаруй сурагчдыг хамрууллаа.
- ✓



ШАРЫН ГОЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВ: Шарын голын БРЭНД ТОР-ыг 12 худалдан авч уриалгад нэгдсэн. Нэмж 2 иргэний БРЭНД ҮЙЛДВЭРЛЭЛ-ийг нийтэд сурталчилсан. “БАХАРХАЛ ОМОГШИЛ” цахим аянд эрүүл мэндийн төвийн хамт олон нэгдсэн. Багаасаа дэгээ зүүгээр нэхмэл нэхэж өдгөө гутал цүнх урлаж яваа Гансүхийн Золоо бүсгүйг онцолж, танилцуулга хийсэн.



ХОНГОР СУМЫН СОЁЛЫН ТӨВ: "БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА"-г ЗДТГ-н ХААТ-н ХЖДҮХАХ Мэргэжилтэн Б.Айсоулетай хамтран зохион байгууллаа. Уг үзэсгэлэн худалдаанд гар урлалын, цагаан идээний, нөөшилсөн даршилсан бүтээгдэхүүнүүдийн үзэсгэлэн гарсан бөгөөд нийт 150 орчим иргэн үзэж сонирхлоо.



ОРХОН СУМЫН СОЁЛЫН ТӨВ: 2022 оны 11 дүгээр сарын 18-ний өдөр “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Дархан-Уул аймгийн Орхон сумын төрийн албан хаагч нарын дунд “АВЬЯАСЛАГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ” урлагийн тоглолт амжилттай зохион байгуулагдаж нийт 120 иргэд үзэж сонирхлоо.



2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 9 дүгээр Цэцэрлэгийн ахлах ангийн 2 бүлэг, бэлтгэл бүлгийн 2 бүлгийн нийт 52 хүүхдүүд анги удирдсан багш нартайгаа ирж Их эзэн Чингис хааны өдөр буюу “Монгол бахархал”-ийн өдрийг тохиолдуулан Соёлын төвийн Орон нутаг судлах танхим, номын сантай танилцлаа.



Орхон Ерөнхий боловсролын сургуулийн Г.Нарангэрэл багштай 6А ангийн сурагчдыг Аймгийн Музейтэй танилцуулах ажил зохион байгуулж ажилласан. Дархан-Уул аймгийн Музейтэй танилцсанаар сурагчид үндэсний өв соёлыг судлах, танин мэдэх мөн түүхээрээ бахархах, үндэсний мартагдсан оньсон тоглоом, наадгайг сэргээн сурах. Мөн Аймгийн Музей зохион байгуулж байгаа боловсролын хөтөлбөрт хамрагдах зорилготой байв.



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САРЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАВ ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН ТАЙЛАН

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР: Дархан-Уул аймаг дахь Монгол II загварын агентлагаас 3 дахь удаагаа зохион байгуулж буй Шилдэг шинэ залуу модел, Шилдэг фото модел шалгаруулах “Super fashion-2022” төвийн бүсийн загварын уралдаанд хамтран оролцлоо.



Соёлын бүтээлч сарын хүрээнд Залуучууд театрын Өвөл цагийн үзвэрийн 46 дахь удаагийн нээлт, Лев. Корсунскийн зохиол, найруулагч МУСТА М.Цогтын бүтээл “Нэр зээлдэгч” драмын жүжиг үзэгчдийн хүртээл боллоо.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МУЗЕЙ: Дархан-Уул аймгийн Боловсролын газар, Музей хамтран бийрэн бичгийн уралдаан зарлаж, уралдаанд ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн дэлгэв. Шинэ алхам сургуулийн багш Цэрэнчимэд, Оюуны Ирээдүй цогцолбор, 4-р сургууль, 18-р сургууль, Од цогцолбор, 9-р сургууль, 30-р сургуулиудаас нийт 42 бүтээл ирсэн.



“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд иргэдийг соён гэгээрүүлэх зорилгоор захирал Д.Жамбалдорж FM-106.5-д “Монгол бахархалын өдөр”-ийн ач холбогдол, онцлог, Их Эзэн Чингис хааны түүх зэрэг олон асуудлаар ярилцлага өгөв.

“Дархан-Уул аймгийн Музейн урлагийн бүтээлүүд” үзэсгэлэнг нийт 134, насанд хүрэгч 37, хүүхэд 97 үзэж сонирхсон бөгөөд “Мандала” боловсролын хөтөлбөрт 9-р сургуулийн анги хамт олон хамрагдаад байна. Мөн Төв номын сангаас нийт номын санч нарыг хамруулсан хотын аялал зохион байгуулж Музейд дэглэгдсэн үзэсгэлэнг үзэж “Соёлын бүтээлч сар”-д нэгдэв.



ТӨВ НОМЫН САН: Дархан-Уул аймгийн Засаг даргын нэрэмжит “Бид эх орны ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд явагдах эссэ бичлэгийн уралдааны дүнг гаргаж, эхний 10 байранд орсон сурагчдад өргөмжлөл мөнгөн шагнал, дурсгалын зүйл, талархал гардуулав. Үйл ажиллагаанд ЕБС-ийн 70 гаруй багш, сурагчид оролцов.



ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОН: Монгол Улс тунхагласны 98 жилийн ойн өдрийг тохиолдуулан зурагт мэдээлэл бэлтгэж пейж хуудсандаа байршуулж, 850 хэрэглэгчдэд хүргэсэн.

Од цогцолбор сургуулийн харьяа “Ухаарлын толь” номын клубын 22 сурагч Хүүхдийн номын ордны үйл ажиллагаатай танилцаад ном уншиж, уншигчийн карт нээлгэж, хуваарьт өдрүүдэд ном тойрсон арга хэмжээ зохион байгуулав.



“Мэргэн шаваа” мэргэжлийн хөгжлийн бүлэг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн “ДАРХАН” салбараас хамтран зохион байгуулсан ҮНДЭСНИЙ БИЧИГ – МАНАЙ ХАМТ ОЛНЫ ӨВ СОЁЛ” цахим контент бүтээх уралдаанд байгууллага хамт олноороо оролцож тусгай байранд шалгарсан.

<https://www.facebook.com/gerlee.oyuka.1/videos/1464332227392620/?idornvanity=763385037703456>

Цолмон Насанжаргал
Бя гаргagt 15:51 цагт · 🌐

ҮНДЭСНИЙ БИЧИГ - МАНАЙ ХАМТ ОЛНЫ ӨВ СОЁЛ
Уралдааны дүн гарлаа

Тэргүүн байр - Насан туршийн боловсролын төвийн хамт олон

Дэд байр - 9 дүгээр сургуулийн хамт олон

Гутгаар байр - Төв номын сангийн хамт олон

Тусгай байр - Од цогцолбор сургууль
2 дугаар сургууль
13 дугаар цэцэрлэг
Хүүхдийн номын ордны хамт олон

2022.11.25

👍👎🗨️ 137 22 сэтгэгдэл · 14 удаа хуваалцсан

Админ

Үндэсний бичиг-Манай хамт олны өв соёл цахим контентийн уралдаанд оролцогч

#Дархан_Уул_аймгийн_хүүхдийн_номын_ордон-ы хамт олны бүтээл

Амжилт хүсье



👍👎🗨️ 239 65 сэтгэгдэл · 117 удаа хуваалцсан

👍 Таалагдлаа 🗨️ Сэтгэгдэл ➦ Хуваалцах

Админ

Үндэсний бичиг-Манай хамт олны өв соёл цахим контентийн уралдаанд оролцогч

#Дархан_Уул_аймгийн_хүүхдийн_номын_ордон-ы хамт олны бүтээл

Амжилт хүсье



👍👎🗨️ 239 65 сэтгэгдэл · 117 удаа хуваалцсан

👍 Таалагдлаа 🗨️ Сэтгэгдэл ➦ Хуваалцах

ШАРЫН ГОЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВ: “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ”- сэдвийн хүрээнд баялаг бүтээж НУТГИЙН БРЭНД-ийг тамгалж буй үйлдвэрлэгчдээ судлан, олонд таниулах ажил 70%-тай явагдаж байна. Энэ удаад:

- Хусны нүүрс үйлдвэрлэгч “Домогт Шарын гол” ХХК



- Дээл урлалын “Өлзий хээ” оёдол эрхлэгч Л. Хишиг-Өлзий

- Эсгий гар урлалын чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг иргэн А. Алтанцэцэг
- Гэрийн нөхцөлд уламжлалт аргаар хэрчсэн гурил үйлдвэрлэж буй ахмад настан Нагима нарын брэндийг танилцуулав.



Шарын голчууддаа эко даавуун тор хэрэглэхийг уриалан хийлгэж буй “НУТГИЙН БРЭНД TOP” дараагийн 20 эзэнд хүрлээ.



ХОНГОР СУМЫН СОЁЛЫН ТӨВ: Улс тунхагласны баяраар Хонгор сумын 16 ахмад настан "Ардын хувьсгалын 100 жилийн ойн" медалиар шагнагдлаа. Хонгор сумынхаа ард иргэдэд өвөл цагийн нээлт Алтан намар тоглолтоороо бэлэг барьсан билээ. Тус урлагийн тоглолтод:

- ✓ Соёлын төвийн эрхлэгч Г.Сайхансанаа “Есөн эрдэнийн орон” дуу
- ✓ Номын санч Я.Цэцэгээ, хөгжмийн багш Б.Асалбек нар “Чиний үгүйд” дуэт дуу
- ✓ 14-р сургуулийн сурагч Н.Содбилэг “Цаатан хүүгийн дуу”

- ✓ Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн 6А ангийн 6 хос бүжигчин хүүхдүүд “Латин америк” бүжиг
- ✓ Хөгжмийн багш Б.Асалбек “Ерөөе өө” дуу
- ✓ 14-р сургуулийн 12А ангийн сурагчид Монгол ардын бүжиг
- ✓ 14-р сургуулийн сурагч М.Дэлгэрзаяа “Ижидээ ирлээ” дуу
- ✓ Эрхлэгч Г.Сайхансанаа, Номын санч Я.Цэцэгээ нар “Морь мину” дуэт дуу
- ✓ Хөгжмийн багш Б.Асалбек “Сумын атаман” уран уншлага
- ✓ 14-р сургуулийн 12А ангийн Т.Анхзаяа, Д.Лхагвахишиг нар “Шинэ жил” дуугаа тус тус үзэгч олноо баясгасан бөгөөд тус тоглолтыг 96 хүн үзэж сонирхсон.



ОРХОН СУМЫН СОЁЛЫН ТӨВ: 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Дархан-Уул аймгийн Зураач урчуудын холбоо хүрэлцэн ирж Орхон сумын ард иргэдэд нээлттэй зургийн үзэсгэлэн дэлгэн толилуулж байна.



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САРЫН ХҮРЭЭНД СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛУУДЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ

Соёлын бүтээлч сарын хүрээнд байгууллагууд нь нийт 3 295 000 төгрөгийн төсвийг зарцуулан ажилласан байна.

Соёл, урлагийн газар: Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулагдсан Ахмадын соёлын биет бус өвлөн уламжлагчдийн наадмын шүүгчийн хөлс, хэвлэлийн зардал, Соёлын бүтээлч сарын хаалтын үйл ажиллагааны нийт 900 000 төгрөгийг зарцуулсан.

Хүүхдийн номын ордон: Хүүхдийн номын ордон нь Соёл, урлагийн газраас 200,000 төгрөгийн төсөв авч бусад 595 000 төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны зардлаас гаргасан байна.

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ТӨСӨВ

Батлав: Захирал Л.Мөнхбаатар

11/1/2022

№	Бараа, материалын нэр	Тоо/х	Нэгж үнэ	Нийт үнэ	Хариуцах ажилтан
Найргийн даага уралдааны шагналд					
1	Медаль	10	5,000	50,000	Номын санч мэдээллийн ажилтан Ц.Наранцэцэг, Т.Сумандадар
2	Үзэг	10	7,000	70,000	
3	Шулгийн ном	10	5,500	55,000	
4	Медаль, үзэгний бичилт	10	3,000	30,000	
Дүн				205,000	
Соёлын бүтээл сарын үйл ажиллагаанд					
1	Хулдаасан хэвлэл	2	55,250	110,500	Нэгжийн дарга Т.Цэрэннадмид, Сан хөмрөгч С.Оюунцэцэг, Номын санч мэдээллийн ажилтан С.Буяннэмэх
2	Номын тэмдэглэл хөтлөх дэвтэр	4	8,500	34,000	
Дүн				110,500	
Алтан хонх асуулт хариултын тэмцээн					
1	Бичгийн цаас	1	18,000	18,000	Сан хөмрөгч С.Оюунцэцэг, Номын санч мэдээллийн ажилтан С.Буяннэмэх
2	Ламинаторын цаас	1	35,000	35,000	
3	Фото цаас	1	9,500	9,500	
Дүн				62,500	
Үндэсний бичиг манай хамт олны өө соёл					
1	Бичлэгийн үнэ	1	330,000	330,000	Номын санч мэдээллийн ажилтан Ц.Наранцэцэг, Т.Сумандадар
Дүн				330,000	
Хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх					
1	Сэтгэхүй хөгжүүлэх тоглоом	5	10,000	50,000	Номын санч мэдээллийн ажилтан А.Ариунтуяа, Б.Өлзийдэлгэр, Ц.Наранцэцэг, Т.Сумандадар
2	Жааз	5	7,500	37,500	
Дүн				87,500	
Нийт дүн				795,500	

Төлөвлөгөө гаргасан: Нэгжийн дарга Т.Цэрэннадмид

Төсөв гаргасан: Нягтлан бодогч Г.Энхжаргал

Музей: “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд аймгийн Музейгээс 200.000 төгрөгийн 3 төрлийн анос хэвлүүлсэн.

1. Гаднах хулдаасан хэвлэл -4,0*1.20см
2. Дотор хулдаасан хэвлэл -2,0*90 см хэмжээтэй аннос
3. Номын нээлтийн хулдаасан хэвлэл -1,20*60 см

3.3 “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд

“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд 4 төрлийн ажлын хүрээнд “Дархан-Уул аймгийн урлагийн бүтээлүүд” үзэсгэлэн, сурагчдад зориулсан Боловсролын хөтөлбөр, иргэдэд зориулсан “Дархантай танилцах хотын аялал”, “Дархан Музейн урлагийн бүтээлүүд” номыг хэвлэн гаргасан байна.

“Соёлын бүтээлч сар” аянд 829 сурагч, нийт 1244 үзэгч хамруулан ажиллалаа.



Залуучууд театр: Хулдаасан хэвлэл болон шатахууны зардалд 300.000 төгрөгийг зарцуулсан.



ДАРХАН-УУЛ АЙМАГ
"ЗАЛУУЧУУД" ТЕАТРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 4/21

Дархан

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-р заалт, Соёлын сайдын 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/364 тоот тушаалыг тус тусүндэслэн ТУШААХ НЬ:

1.2022 оны 10 дугаар сарын 25-ны №386 албан тоотын удирдамжийн дагуу "Соёлын бүтээлч сар"-ын үйл ажиллагааг удирдамжийн дагуу үр бүтээлтэй зохион байгуулсугай.

2.Дээрх үйл ажиллагааг мэргэжлийн өндөр төвшинд зохион байгуулан ажиллахыг уран сайхны удирдагч (Г.Саранчимэг), төлөвлөгөө болон төсвийг хавсралтаар гаргахыг маркетингийн албаны нэгжийн дарга (М.Ерболот) нарт үүрэг болгосугай.

3.Соёлын бүтээлч сарын үйл ажиллагаанд зарцуулагдах 300.000 /гурван зуун мянган төгрөг/-ийг төсвийн дагуу нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг санхүү албаны нэгжийн дарга (М.Отгонбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН
А.БОЛОРСҮХ
20221110

Даргын 2022 оны 11 дугаар сарын 01-ны өдрийн №А/21 тоот тушаалын хавсралт-2

"Соёлын бүтээлч сар"-ын үйл ажиллагааны зардлын төсөв

№	Үзүүлэлт	Тоо ширхэг	Үнэ	Бүгд
1	Анонс /440x230/	1	131400	131400
2	Шатахуун	1	168600	168600
Нийт үнэ				300.000

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР